

**ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН ДЭД ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА  
2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр, Даваа гараг**

**Хуралдааны тэмдэглэлийн агуулга**

**Хуралдааны товч тэмдэглэл:** 1-3

**Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:** 4-20

---

**1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./** 4-20

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны  
12 дугаар сарын 09-ний өдөр /Даваа гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Д.Батбаяр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 12 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 18 цаг 50 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: П.Ганзориг, З.Мэндсайхан;  
Эмнэлгийн чөлөөтэй: Х.Булгантуяа.

**Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг хавсран гүйцэтгэгч, Тамгын газрын дарга М.Нармандах нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, мөн албаны референт Б.Мөнгөн-Аргамж, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт С.Төрмөнх нар байлцав.

Төсвийн төслийн танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав нар танилцуулав.

Танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Д.Батлут, Д.Батбаяр нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан нар хариулж, тайлбар хийв.

*Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Д.Батбаяр:** Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын гаргасан, Сургуулийн барилга Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 34 дүгээр хороонд орших 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилга нийт төсөвт өртөг нь 15 тэрбум 795.2 сая төгрөг, энэ 2025 оны санхүүжих дүн нь 11 тэрбум 795.2 сая төгрөг гэсэн энэ заалтаас 1 тэрбум 800 сая төгрөг бууруулж, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр сургуулийн өргөтгөлийн барилга 320 хүүхэдтэй өргөтгөлийн барилгын нийт төсөвт өртөг нь 7 тэрбум 113.1 сая төгрөг гэж, энэ төслийн нэмэгдэх өртөг нь 1 тэрбум 800 сая төгрөг байна гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн:	5
Татгалзсан:	4
Бүгд:	9

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 9 гишүүнээс 6 гишүүн дэмжиж, 66.6 хувийн саналаар санал дэмжигдлээ

### **Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.**

Дэд хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 19 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.*

Дэд хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 58 минут үргэлжилж, ирвэл зохих 12 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 75.0 хувийн 19 цаг 48 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН  
ДЭД ХОРООНЫ ДАРГА

Д.БАТБАЯР

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр,  
Даваа гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим  
18 цаг 50 минут.

### ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Д.Батбаяр:** Эрхэм Дэд хорооны эрхэм гишүүдийн энэ оройн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя. Далай Батбаяр 5 дугаар бүс ирсэн байна. Ринчиндоржийн Батболд гишүүн ирсэн байна. Жигжидийн Батжаргал гишүүн байна. Дамбын Батлут гишүүн байна. Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн байхгүй байна. Пүрэвжавын Ганзориг гишүүн байхгүй байна. Гонгорын Дамдинням гишүүн байна. Батжаргалын Заяабал гишүүн байхгүй байна. Загджавын Мэндсайхан гишүүн байхгүй байна. Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн байна. Банзрагчийн Түвшин гишүүн байна. Даваагийн Цогтбаатар гишүүн байна. Ингээд ирц 66.7 хувьтай байгаа учраас Дэд хорооны хурал эхэлснийг мэдэгдье.

Дэд хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн өргөн мэдүүлснээр юм байна. Хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ гэж байна.

Тэгэхээр хэлэлцэх асуудалтай холбоотойгоор саналтай гишүүн байна уу?

Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг эхэлж байна.**

Тэгэхээр ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Монгол Улсын Сангийн сайд Болдын Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч Ядамын Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Цэвэгсүрэнгийн Наранчимэг, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын захирал тэргүүлэх аудитор Дэлгэрийн Энхболд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жигжидийн Ганбат, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга энэ байхгүй байна тээ? Цэнд-Аюушийн Ганцэцэг дарга байхгүй байна уу? Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг хавсран гүйцэтгэгч, Тамгын газрын дарга Мухраагийн Нармандах дарга байна. Энх-

Амгалан дарга байхгүй байна. Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Мижиддоржийн Санжаадорж дарга хуралтай байгаа юу? Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Ганболдын Золбоо, сайд нь байгаа учраас тэгээд гайгүй яриа яриад явчих байх. Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Лувсандоржийн Сонор, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга Зоригтбаатарын Энхболд, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Жамьяншаравын Дэлгэржаргал дарга, Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга Отгондэмбэрэлийн Мягмардорж дарга, Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Энхтөрийн Батмөнх, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Лувсанвандангийн Ичинноров, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Булганхүүгийн Ганзориг, Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Батнямын Отгонцэцэг, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Лувсандоржийн Гантогтох хүрэлцэн ирсэн байна. Тэгэхээр яг хажууд зэрэгцээд бас бусад өөр Байнгын хорооны хурал болж байгаа учраас ажлын хэсэгтэй холбоотой асуулт, санал гарах юм. бол дуудаж ирүүлээрэй ажлын хэсгийнхэн, манай ажлын албаныхан. Ажлын хэсгийг хэсгийн бүрэлдэхүүнийг танилцууллаа.

Одоо Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна.

**Б.Жавхлан:** Баярлалаа.

Эрхэм Зарлагын хяналтын дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурал Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслийг 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр хэлэлцсэн баталсан.

Үүний дараа Монгол Улсын Ерөнхийлөгчөөс гадаад зах зээлийн тогтворгүй байдал, түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэн 2025 оны төсвийг үр ашигтай, хэмнэлттэй, алдагдалгүй батлах шаардлагатай гэсэн үндэслэлээр 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан.

Улмаар Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэн хүлээн авч алдагдалгүй төсөв батлах чиглэл өгсний дагуу Засгийн газраас Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг шинэчлэн боловсруулж дахин өргөн барилаа.

Төсвийн төсөлд зардлыг бууруулахад дараах үндсэн зарчим баримталлаа.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмж, Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нийгмийн халамжийн сангаас олгох хүүхдийн мөнгөн тэтгэмж, халамжийн тэтгэвэр, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, асаргааны тэтгэмж, түүнчлэн төрийн албан хаагчийн цалин хөлс болон тэтгэвэрт гарахад 1 удаа олгох тэтгэмж, хөдөө орон

нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж, зээлийн үйлчилгээний төлбөр мөн хуульд заасны дагуу Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос төсвийг нь хянаж, жилийн төсөвт тусгуулахаар ирүүлсэн байгууллагууд болон Хүний эрхийн Үндэсний Комисс зэрэг байгууллагуудын урсгал зардлыг тус тус хэвээр нь үлдээлээ. Хэвээр үлдэж байна.

2.Төсөвт байгууллагын үйл ажиллагааны зарим зардлыг дараах байдлаар 10-100 хувь бууруулна. Салбар харгалзахгүйгээр бүх төсөвт байгууллагуудын тавилга, эд хогшил худалдан авах, сургалт, семинар, хурал зөвлөгөөн хийх, биеийн тамирын уралдаан тэмцээн зохион байгуулах, гэрээт ажилтан ажиллуулах, дуудлагын автомашин хөлслөх, зөвлөл, хороо, комиссын гишүүний урамшууллын зардлыг 100 хувь бууруулах, соёлын эрхийн бичиг, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, Кино урлагийг дэмжих сан, Засаг захиргааны нэгж, төрийн захиргааны байгууллагыг үр дүнгээр шагнах, урамшуулах, идэвхтэй амьдралын хэвшлийг дэмжих болон эрүүл идэвхтэй амьдрал хөтөлбөрийн зардлыг 100 хувь бууруулна.

Эрүүл мэнд болон тусгай чиг үүргийн байгууллагаас бусад бүх байгууллагын тээвэр шатахууны зардал, төрийн өндөр дээд айлчлал болон гаднын өндөр түвшинтэй зочин төлөөлөгч хүлээн авахаас бусад гадаад албан томилолтын болон зочин төлөөлөгч хүлээн авах зардал, эрүүл мэнд, боловсрол, батлан хамгаалах, гадаад харилцаа, Хууль зүй, дотоод хэргийн салбараас бусад салбарын дадлага, бэлтгэл, сургуулилт хийх зардал, бүх шатын төсвийн байгууллагын дотоод албан томилолт, бичиг хэргийн зардал, багаж, техник хэрэгсэл, худалдан авах зардлыг тус тус 50 хувиар бууруулъя.

Дээр дурдсан 50-100 хувь бууруулах зардлуудаас гадна байр ашиглалтын зардал, хангамж, бараа материал, норматив эм бэлдмэл, нормын хувцас, хоол, урсгал засвар, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас, шилжүүлэг, эргэж төлөгдөх зээл, бараа, үйлчилгээний бусад зардал, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх арга хэмжээ, боловсролын тэтгэлэг, авто зам, гүүрэн байгууламжийн засвар ашиглалтын зардлыг 10 хувиар тус тус буурууллаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан төсөл, арга хэмжээнээс гэрээ байгуулсан ажлыг эхлүүлсэн төслүүдийг дуусгана. Гэрээ байгуулаагүй, ажил эхлээгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг эрэмбэлж хойшлуулъя. Зарим их засвар, ТЭЗҮ, зураг төсөв, тоног төхөөрөм хэмжээнд санхүүжилтийг бууруулж, хэлэлцээрийн шатад байгаа төслийг хойшлуулна. Гадаад зээлийн ашиглалтыг бууруулж, хэлэлцээрийн шатад байгаа үндэсний хиймэл дагуулын төсөл болон бусад төслийн зээлийн ашиглалтыг хойшлуулъя.

7.Хавдар судлалын үндэсний төв-2 хөрөнгө оруулалтыг нэмж тусган тусгалаа.

Нэгдсэн төсвийн нийт орлогыг төсвийн хөрөнгө оруулалт, зарлагын бууралттай холбогдуулан 394.8 тэрбум төгрөгөөр буурахаар тооцлоо. Ингэснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого тусламжийн дүн 33.5 их наяд төгрөг буюу ДНБ-ий 35 хувь, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 33.5 их наяд төгрөг буюу ДНБ-ий 35 хувьд хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалгүй болж байна. Мөн суурь тэнцэл ДНБ-ий 3.3 их, 3 хувийн эерэг байхаар болж байна.

Зарлагын хяналтын дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн 11 хуулийн төсөл, 4 Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Эдгээр хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Батбаяр:** Сангийн сайд Болдын Жавхланд баярлалаа.

Одоо Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдэд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна.

5 номерын микрофоныг нээе.

**Д.Загджав:** Та бүхэндээ энэ үдшийн мэндийг өргөн дэвшүүлье.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Төрийн аудитын байгууллагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг гүйцэтгэн аудитын тайлан, дүгнэлтийг Улсын Их Хурал Засгийн газарт хүргүүлсэн болно.

\

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс гадаад зах зээлийн тогтворгүй байдал, түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэн 2025 оны төсвийг үр ашигтай, хэмнэлттэй, алдагдалгүй батлах шаардлагатай гэсэн үндэслэлээр 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан нь цаг үеэ олсон чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон байна.

Иймд Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар Ерөнхийлөгчийн хоригийг 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр хэлэлцэн хүлээн авч алдагдалгүй төсөв батлах чиглэл өгсний дагуу Засгийн газраас Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг шинэчлэн боловсруулж дахин өргөн барьжээ.

2025 оны төсвийн төсөлд хийсэн аудитын зорилго нь Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангасан эсэх, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх зорилгод нийцсэн эсэхийг хянаж дүгнэхэд чиглэсэн.



Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 23.1-д заасан шалгуурт нийцэж байгаа эсэх талаар дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд

1.Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл нь улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлоготойгоор нийцэж байна. Засгийн газрын өрийн үлдэгдэл 2025 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 41.9 хувьд хүрэх төсөөлөлтэй байхаар тооцоолон тусгасан нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.3-д заасан төсөв, санхүүгийн аюулгүй байдлын бодлогын зохистой харьцааны түвшинд байна.

2.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, нийт зарлагын хэмжээ 33.10-ны 5 их наяд төгрөг, ДНБ-ий 35.2 хувь байхаар төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг анх удаа алдагдалгүй төлөвлөсөн нь төсвийн төлөвлөлтөд ахицтай үзүүлэлт болсон байна. Төсвийг алдагдалгүй байлгах зорилгоор төсвийн төслийн нийт зарлагаа цэвэр зээлийн дүнг 2 их наяд 301.9 тэрбум төгрөгөөр, нийт орлого ба тусламжийн дүнг 394.8 тэрбум төгрөгөөр тус тус бууруулж, дахин өргөн мэдүүлсэн байна.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 8 дугаар, 6 дугаар зүйлд заасан нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх. Нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухайн жилийн дотоодын нийт төсвийн 2-оос дээш хувийн ашигтай байх, нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн ДНБ-ий 30 хувиас хэтрэхгүй байх, Засгийн газрын өрийн нэгтгэсэн дүнг нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр ДНБ-ий 60 хувиас хэтрэхгүй байх гэсэн тусгай шаардлагуудыг тус тус хангасан байна.

3.Монгол Улсын 2025 оны төсвийн төсөл нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын үзэл баримтлалд, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн боловч дараах асуудлыг цаашид анхаарах нь зүйтэй.

1.Гадаад хүчин зүйлийн нөлөөлөл уул уурхайн салбарын голлох нэрийн бүтээгдэхүүний эрэлтээс шалтгаалж нүүрсний экспорт төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй тохиолдолд зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах, орлого тасрах эрсдэлийг тооцох шаардлагатай.

2.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг төсөлд өөрчлөлт оруулах бүрд нэмж өөрчилж байгаа нь төсвийн удирдлагын зарчим, сахилга батыг алдагдуулж, дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн ачааллыг бууруулж байна.

3.Цахим систем болон техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын өртөг зардлыг тооцож төлөвлөх, хянах, хэрэгжүүлэх, хүлээн авахтай холбоотой зохицуулалт, жишиг үнэ, заавар журам хангалтгүй байгаа нь төсөвт өртгийг үндэслэлтэй тооцож үр ашигтай төлөвлөхөд сөргөөр нөлөөлж байна.

4.Төсвийн урсгал зарлагыг хумьж, зарим хэрэгжиж эхлээгүй хөтөлбөр, үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөсөн нь төсвийн зарлагын ДНБ-ийн үздэг харьцааг бууруулсан нь сайн талтай боловч, зардлыг хэт механикаар хассан нь 2025 онд төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулах, тоо хэмжээг багасгах эрсдэл үүсгэх магадлалтай байна.

5.Төрийн үйлчилгээг илүү цомхон бүтэц, ухаалаг байдлаар үзүүлэхийн тулд төрийн өмчит зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх тогтолцооны өөрчлөлтийг хууль, эрх зүйн орчинд бүрдүүлэх шаардлагатай байгаа юм.

6.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөвтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 12-т төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын хуулийн этгээдээр аудит хийлгэж болно. Тухайн санхүүгийн жилд аудит хийлгэх төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт болон аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах эрхийг Засгийн газар тогтооно гэж тусгасан нь Монгол Улсын Хурлын Засгийн газарт тавих хяналтын зарчмыг алдагдуулахаас гадна Монгол Улсын Үндсэн хууль, түүний эш болон гарсан хууль тогтоомжтой нийцэхгүй байгааг анхаарах, түүнчлэн Улсын Их Хурлын даргаас өгсөн чиглэлийн дагуу аудитын зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байгаад бүх шатын төсвийн захирагчид анхаарч ажиллах шаардлагатай байгааг онцлон тэмдэглэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Батбаяр:** Монгол Улсын 2025 оны төсвийн төслүүдийн талаарх Сангийн сайдын болон Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав нарын дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?

Дамдинням, Батлут, би бас үг асууна. Ингээд надаар тасалчих. 3 гишүүн үг асууна.

Ингээд Дамдинням гишүүний микрофоныг өгье.

**Г.Дамдинням:** Оройн мэнд. Төсвийн зарлагын дэд хорооны гишүүддээ энэ оройн мэндийг хүргэе.

2025 оны төсөв ингээд орж ирж байна. Засгийн газар бол нэлээн шахсан чангахан л төсөв оруулж ирлээ. Тэгээд одоо бид нар бол шинэ дэг гаргаж байгаад явж байгаа учраас батлаад явуулахаас өөр арга алга. Одоо бид нарын ярих ёстой асуудал бол Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль, тэгээд энэ төрийн өмчит аж ахуйн нэгжүүд, төрийн өмчийн энэ ашигт үйл ажиллагааг нэмэгдүүлэх зэрэг энэ ажлууд руу л анхаарах ёстой болчхоод байгаа юм. Энэ том төслүүдээ явуулах, Орано-гийнхаа гэрээг явуулах, Чайна Энержигийн гэрээг явуулах гээд. Үгүй бол бид нар бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт байхгүй. Засгийн газраасаа ийм юм нэхэх эрх ч үгүй болно. Тэгэхээр энэ асуудлуудаа ер нь Засгийн газар хэзээ оруулж ирье гэж байгаа вэ? Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт бол энэ сүүлийн үед өчигдөр хэвлэл мэдээллийн байгууллагуудаар их яригдаад эхэллээ. Энэ Евроазийн худалдааны байгууллагатай чөлөөт худалдааны гэрээ байгуулна гэдэг асуудал нэлээн яригдаж байна. Бид мөнхийн хөршүүдтэйгээ найрсаг харилцаатай, эдийн засгийн харилцан ашигтай харилцаатай байх ёстой. Худалдааны хэлэлцээр гэдэг бол ашигтай, ашиггүй гэдэг ийм л шалгуур дээр явагддаг байх ёстой. Эцсийн дүндээ Монголын төр, Монголын ард түмнийхээ талд зогсох ёстой. 3.6 сая ард иргэдийнхээ ахуй амьдралыг авч явж байгаа энэ худалдаа, бизнес эрхэлж байгаа хүмүүсийнхээ талд зогсож байх ёстой. Олон олон ЖДҮ-лэлийнхэн, олон олон хөдөө аж ахуйн

салбарынхан санаа зовж бидэнд хандаж байна. Бид энэнээс айж байна гэж болгоомжилж байна.

Тэгэхээр хамтарсан ажлын хэсэг гарч, хоёр улсын ч юм уу, бусад улсуудтай нийлсэн ажлын хэсэг гарч, манай улсад ашигтай байх уу, үгүй юү, манай улсын жижиг, дундын салбарынхан, хөдөө аж ахуйнхан, бусад энэ бизнес эрхэлж байгаа, худалдаа эрхэлж байгаа энэ татвар төлөгчид ажлын байр бий бологчдод эрсдэл учруулах уу, үгүй юү гэдгээ хамтарсан ажлын хэсгийн хүрээнд судалсан юм байгаа юү? Энийг бас ард түмэнд бас хэлчихвэл их зүгээр байгаад байна.

Гуравдугаарт, энэ төрийн өмчтэй холбоотой энэ манай бүтэн яам нүүлгэж авч яваад ард нь үлдэж байгаа Төрийн өмч, газар онц хэрэгтэй төрд байж байх ёстой энэ зүйлсийг худалдах гээд байгаа энэ Хөдөө аж ахуйн яамны сангуудын өмч, хөрөнгийг гаргах гээд байгаа асуудлууд дээр ер нь ямар байдлаар ёстой хандах ёстой вэ? Энэ болохгүй л харагдаад байгаа юм даа. Орон сууц болгочих гээд л ингээд л яваад байгаа. Тэгэхээр энэ асуудлыг бид нар яаж харах ёстой юм бэ гэдэг ийм 3 асуулт.

**Д.Батбаяр:** Том төслүүдийг хэзээ оруулж ирэх вэ гэдэг асуудал дээр Сангийн сайд хариулах уу?

**Б.Жавхлан:** Дамдин гишүүний асуултад хариулъя.

Одоо яг үнэхээр яг тэр ажил бидний өмнө тулж ирж байна. Яагаад гэхээр бид төсвөө нэлээн хумиад, төсөв дээр шийдэх хөрөнгө оруулалтууд маань цаашаа улам хязгаарлагдах нь. Ер нь сургууль, цэцэрлэгтэйгээ л биеийн тамирын заал, цэцэрлэг, жижиг эмнэлэг үүнийгээ л төсөв дээрээ шийддэг ийм формат руу шилжлээ.

Цаашдаа томоохон төсөл, хөтөлбөр, бүтээн байгуулалтын ажлуудыг төсвөөс гадуур бусад өөр ямар эх үүсвэрүүд байна? Төр, хувийн хэвшлийн түншлэл, Хөрөнгө оруулалтын тухай хууль, мөн цаашаагаа өшөө Валю эксченж гэж бид нар их ярьдаг боллоо шүү дээ тийм ээ? Баялгийн солилцоо. Өөрөөр хэлбэл газрын хөрсөн доороо бид нар асар их баялаг байгаад байдаг. Үүнийгээ бүтээн байгуулалт болгож, хэрхэн яаж хувирах вэ гэдэг ийм эрх зүйн орчин, яаралтай шийдлүүдээ гаргаж ингэж цаашаа хөдөлгөх шаардлагатай болж ирж байна гэсэн үг.

Яг тодорхой асуусан учраас Хөрөнгө оруулалтын тухай хууль өнөө, маргаашгүй өргөн баригдана. Одоо яг манай яаман дээр үзэл баримтлал батлах гээд хүлээгдэж байгаа. Үүний дараа Засгийн газрын хуралдаан руу ороод л тэгээд л өргөн баригдах замдаа орчихно доо гэсэн үг.

Евроазийн чөлөөт худалдааны энэ олон улсын гэрээн дээр бид нар мэдээж нэлээн ул суурьтай ярилцах ёстой. Байгаа нөхцөл байдал, одоо бий болсон манай үйлдвэрлэлийн дотоод балансаа их сайн харах хэрэгтэй. Баланс өсөн нэмэгдэж байгаа хэрэглээ ер нь 3-4 төрлийн өсөн нэмэгдэж байгаа эрэлт хэрэгцээ. Тэрийгээ хэрхэн яаж хангаж байгаа юм дотоодын үйлдвэрлэлээрээ. Гаднаас орж ирэх импортын хэмжээ нь дотоодын үйлдвэрлэлд хэрхэн яаж нөлөөлөхөөр байна ийм олон балансуудыг бараа бүрдээ нэг бүрчлэн харж байж энэ цаашаагаа явах болов уу гэж ингэж бодож байна.

Гэхдээ өнөөдрийг хүртэл энэ чинь яг шинэ юм биш, 10 гаран жил нөр их бас хөдөлмөр, хэлэлцээр, хэлэлцээрийн үр дүнд өнөөдрийн түвшинд ирчхээд байгаа юм. Тэгэхдээ тэр хооронд манай бас дотоодын үйлдвэрлэл бас өөр түвшинд ирчихсэн.

Тийм учраас эд нарыг, эдгээрийгээ хараад олон талаас нь харж байгаад мэдээж Дамдинням гишүүнтэй 100 хувь санал нийлж байгаа зүйл яг Монголын ард түмэн Монгол талдаа мэдээж эрсдэлгүй, улмаар дотоодын үйлдвэрлэлдээ илүү ээлтэй, манай экспортод ч бас ээлтэй энэ тал дээрээ шийдвэрээ гаргаад явна гэж ингэж харж байна.

Тийм учраас ойрын хугацаанд бас Улсын Их Хурал дээр энэ талаар Засгийн газраас би мэдээлэл хийх болов уу гэж ингэж бодож байна. Тийм .

Тэр Хөдөө аж ахуйн яамнаас хүн байна уу?

**Д.Батбаяр:** Хөдөө аж ахуйн яамнаас хүн байхгүй тийм ээ? Эдийн засаг, хөгжлийн яамны Энх-Амгалан дарга байна уу ? Та хариулах уу? 9 номер дээр суучих.

**Л.Энх-Амгалан:** Саяын хэлэлцээртэй холбоотой асуудал дээр хариул гэж ойлголоо.

Энэ гадуур сошиал дээр Евроазийн эдийн засгийн холбоонд элсэх гэж байна гэсэн юм нэлээн явж байгаа. Эхлээд тэр холбоонд элсэх тухай асуудал огт байхгүй гэдгийг хэлье. Зөвхөн худалдааны түр хэлэлцээр хийж байгаа. Сүүлийн 2, 3 жил олон шатны хэлэлцээрүүд хийсэн. 2 талаас нийт 375 бараа, бүтээгдэхүүнийг харилцан экспорт, импортын тарифгүйгээр худалдаалах тийм л худалдааны хэлэлцээр. Энэ дээр Оросын талаас ихэвчлэн манайх манай импорт 5-10 хувьтай байдаг. Гэтэл манай бүтээгдэхүүнүүд Евразийн эдийн засгийн холбооны улсуудад экспорт хийх гэхэд 15-50 хувийн импортын тарифтай байдаг. Тэр ашигтай юу гэдэг дээр олон улсын Жи 50 гээд дата бааз байдаг. Байгаа. Бүх улсуудын.../минут дуусав./

**Д.Батбаяр:** Ахиад гүйцээгээд хариулчих уу? Дамдинням гишүүн ахиад тодруулчихъя.

**Г.Дамдинням:** Тэгэхээр яах вэ би энэ Эдийн засаг, хөгжлийн яамныхнаас асуугаад байна л даа. Манай хамгийн их ажлын байрыг шингээгээд ингээд явж байдаг хөдөө аж ахуй, жижиг, дундын салбарын сайд нь энэ гэрээг хийх ёстой гэчихсэн ярьж явна лээ. Тэгээд би бол манай Засгийн газар, Эдийн засгийн хөгжлийн яам, Гадаад харилцааны яамныхан тооцоолол хийчихсэн юм байна даа гэж бодоод байгаа юм. Бид нар дэлхийн орнуудтай худалдаа хийгээд, Хятадтайгаа хийгээд, урд хөрштэйгөө хийгээд хэдэн доллар олж ирээд, тэрийгээ хойд хөршдөө өгөөд, түлш шатахуун аваад, манай гадаад худалдааны баланс харах юм бол манайх алдагдалтай явж байх ёстой тийм биз? Тэгэхээр яг энэ хэлэлцээрийг хийх юм бол Монгол Улсын салбар тэр бараа, бүтээгдэхүүнүүдэд салбар, чиглэл болгон дээр бизнес эрхэлдэг хүмүүст ямар эрсдэл ногдох юм, очих юм? Бизнесээ хамгаалах юм уу гэдэг асуудлыг үнэлгээгээ хэлээдхээч.

**Д.Батбаяр:** 9 номерын микрофон.

**Л.Энх-Амгалан:** Олон улсын гадаад худалдааны, бүх улсуудын гадаад худалдааны дата-г бүтээгдэхүүн болгоноор нь нэгтгэсэн Жи 50 гээд дата бааз байдаг. Тэр дата бааз дээр манай улсын тоонууд бүгд байдаг. Энэ дата бааз дээр тулгуурлаад яг харилцан татвар хөнгөлж байгаа бараа болгон дээр нь тохируулга хийгээд судалгаа хийсэн байгаа. Энэ судалгааг сүүлийн 1 жилийн хугацаанд хийсэн. Энэ судалгаагаар одоо яг хамгийн сүүлд тохирсон 375 бараа, бүтээгдэхүүнээ оруулаад үзэхэд манай улсын гадаад худалдааны тэнцэлд эерэг нөлөөтэй гэж гарсан байгаа. Мэдээж зарим нэг бараа, бүтээгдэхүүн дээр сөрөг нөлөөтэй бараа, бүтээгдэхүүнүүд байна.

Гэхдээ ерөнхий нийт дүнгээрээ ашигтай байгаа манайд. Ашигтай гэсэн тэр судалгааг үндэслээд хэлэлцээрүүд цаашаа үргэлжилсэн. Зарим бараа, бүтээгдэхүүн дээр алдагдал өндөр хүлээж байвал тэр бараа, бүтээгдэхүүнүүдийг хасах, нэмэх гэсэн хэлэлцээрүүд үе шат болгонд хийгдээд явдаг тийм л хэлэлцээр байгаа.

**Д.Батбаяр:** Ахиад тодруулга Дамдинням гишүүн.

**Г.Дамдинням:** Үгүй ер нь гадаад худалдаа хийх гээд байгаа бол түнштэйгээ цуг ажлын хэсэг гаргаж байгаад л судалгаа тооцоогоо хэлээд л хийгээд л нийлдэг шүү дээ. Бизнес хийх гэж байгаа бол 2 талд ашигтай, ашиггүй. Ерөөсөө л маш энгийн. Түүнээс олон улсын татвар да да да тэр бол худлаа асуудал шүү дээ. Битгий төөрүүл. Эдийн засаг, хөгжлийн яамныхан шууд л хэл. Манайд ашигтай, ашиггүй. Тийм ашигтай, ашиггүй. Тэрийгээ хэл.

Хоёрдугаарт, миний түрүүний асуусан, энэ нөгөө Хөдөө аж ахуйн яамны өмч хөрөнгөтэй холбоотой асуулт дээр бас хариулт авчихмаар байна. Энэ ингэж хүний дураар шийдэж, ашиг сонирхлын зөрчилтэй салбарыг удирдаж байгаа хүний чиглэлээр явж, тэнд очиж орон сууц болж төрийн өмчөөр хүнд орон сууц авч өгч болохгүй шүү дээ. Хориотой байхгүй юу. Тэгэхээр энэ дээр хариулт авчихмаар байх юм.

**Д.Батбаяр:** Байж байгаарай. Эхлээд 9 номерын микрофоныг нээгээд сая Дамдинням гишүүний асуултад гүйцээгээд хариулчих.

**Л.Энх-Амгалан:** Тодорхой судалгаа хийсэн гэдгийг дахиад хэлье. Ашигтай гарсан гэдгийг дахиад хэлье. Ашигтай гарсан учраас бид хэлэлцээрийг үргэлжлүүлээд өнөөг хүртэл энэ түвшинд хүртэл явуулсан байгаа. Энэ судалгааг зөвхөн Монголын талаас 2, тэр глобал түвшинд байдаг дата бааз ашиглаад хийсэн байгаа. Ерөнхий яагаад ийм хэлэлцээр хийгээд байгаа вэ гэвэл эдийн засгийг төрөлжүүлэх асуудал яригддаг. Энэ хүрээндээ гадаад худалдаагаа илүү өргөн нээлттэй байлга гэсэн үүрэг, даалгавруудыг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө дээр Их Хурлаас баталж өгсөн байдаг. Энэ бүх баримт бичгүүдийн хүрээнд энэ хэлэлцээрийг хийгээд явж байгаа гэдгийг дахиад хэлье.

Хамтарсан ажлын хэсэг байгуулаагүй. Зөвхөн 2 талаас тус тусдаа хийсэн судалгаанууд хийгдээд явж байгаа. Гэхдээ ашиглаж байгаа дата баазууд яг дэлхий даяар бүх улсууд энэ төрлийн хэлэлцээр хийхэд ашиглаад явдаг тийм дата бааз ашигласан байгаа.

**Д.Батбаяр:** Жавхлан сайдын микрофоныг нээчихье.

**Б.Жавхлан:** Тийм, Дамдин гишүүний асуултад нэмж хариулъя.

Хөдөө аж ахуйн яам Дархан хот руу нүүсэн асуудал энэ бол ингээд тусдаа асуудал тээ. Төрийн албан хаагч нарыг тэнд байр орон сууцаар амьдрах нөхцөл байдлаар нь тодорхой хэмжээнд хангах нь дараагийн бас ингээд даалгавар болчхож байгаа юм. Ингээд төсөв дээрээс, 24 оны төсөв дээрээс болон 25 оны төсөв дээрээс шууд энэ санхүүжүүлэх энэ боломжууд нь цаг хугацааны хувьд энэ чинь яаралтай учраас тийм шийдэл төсөв дээрээс байхгүй байсан. Ингээд харин Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас оруулж ирсэн саналаар тус яамны өөрсдийнх нь мэдэлд байдаг тийм байх аа? Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар бүртгэлтэй билүү дээ ямар ч байсан тэр өмнөх үүссэн байсан өрөндөө хураагдаж авсан 1 объект, Ганбат дарга аа 1 объект билүү 2, 3 объект билүү?

**Д.Батбаяр:** Жавхлан сайд гүйцээж хариулъя.

**Б.Жавхлан:** 3 багц объектыг зарж борлуулаад олсон орлогоор нь Дархан-Уул аймагт төрийн албан хаагчийн байр, орон сууц өөрөөр хэлбэл энэ үндсэн хөрөнгө бэлтгэхэд зориулагдана гэсэн Засгийн газрын шийдвэр гарсан байгаа.

Тэгэхээр энд нь тухайлан албан хаагчид зориулсан, хувьд нь зориулсан ийм хөрөнгө оруулалт, худалдан авалт юм уу, хөнгөлөлт чөлөөлөлт бол биш шүү. Энд яг төрийн албан хаагч нарын тэнд амьдрахдаа оршин суух ийм орон сууц юм байгаа юм. Өөрөөр хэлбэл, төрийн өмчит бүртгэлтэй ийм хөрөнгө бэлдэнэ гэсэн үг. Ийм шийдвэр Засгийн газар дээр гарсан.

**Д.Батбаяр:** Баярлалаа. Батлут гишүүн асуулт асууна.

**Д.Батлут:** Оройн мэнд хүргэе.

Би энэ төсөв дээр бас ганц, хоёр сэдэв барьж байгаад нэлээн тал талаас нь асууж үзээд байгаа юм. Би аудитын байгууллага асуух гэж байгаа юм. Өнгөрсөн 5 дахь өдрийн чуулган нэлээн оройтож тарсан. Тэгээд би тэр ас чуулган дээрээс Эдийн засаг, хөгжлийн сайдаас энэ нүүрсний үнэтэй, энэ уул уурхайн бүтээгдэхүүний үнэтэй холбоотой асуудал ирэх он жилүүдэд ямар байх юм бэ? Дэлхийн зах зээл дэх үнэ нэлээн уналттай байх байхаар байна гээд тодорхой хувь хэмжээгээр нь хэлээд орлогоо бид яаж төвлөрүүлэх юм, энэ дээр дахин тооцоолсон зүйл байгаа юм уу гэж асуусан. Харамсалтай нь тэр сайд ер нь нүүрсний үнэ, уул уурхайн бүтээгдэхүүний үнэ унана гэдгийг хэн хэлээд байгаа юм, би бараг мэдэж байна ухааны юм яриад л загнаж байна лээ л дээ Гантөмөр сайд.

Энэ чинь аудитын байгууллагын мэдээлэл дунд ороод ирсэн мэдээллийг л би асуусан шүү дээ. Тэгээд би асуух гэж байгаа аудитаас. Та бүхэн энэ уул уурхайн биржийн уул уурхайн бүтээгдэхүүний үнэ ирэх онд уналттай байна, дан ялангуяа уул уурхайн бүтээгдэхүүний 53 хувийг эзэлдэг нүүрс бол тонн тутамдаа 35 доллароор унахаар төсөөлөл байна гэдгийг цээжээр биччихсэн юм уу, эсвэл судалгааны байгууллагын дүгнэлтүүдийг гарч хэлээд байгаа юм уу? Би энэ дүгнэлттэй чинь холбоотой асуултыг асуусан. Тэгээд тухайн үед бас доройтсон байсан учраас хурлын дарга надад бас дараагийн үг хэлэх боломжийг олгоогүй юм. Энэ дээр нь хариулт авчихъя. Тэгээд ууртай сайдын өмнөөс бас хэлэх үг, тайлбарыг нь би сонсмоор байгаа юм л даа.

Хоёрдугаарт нь уул уурхайн бүтээгдэхүүний энэ эдийн засгийн өгөө үр өгөөжтэй дагалдах элементийн асуудлыг бас тодруулах гээд байгаа юм. Би ингээд Сангийн сайдаас ч асуусан, бусад холбогдох яамдын хүмүүсээс хариултуудыг нь авч байгаа. Аудитын байгууллага бол хууль хэрхэн хэрэгжиж байгаа вэ гэдэг дээр хяналт, шалгалт хийх байгууллага. Энэ боловсруулах үйлдвэрүүдээсээ, дагалдах элементүүдээс АМНАТ аваад байгаа нь хуулийн хүрээнд зөв гэж үзэж байгаа юу Аудитын байгууллага? Энэ дээр надад хариулт өгөөч. Би яагаад ингэж байгаа вэ гэвэл хуульд тодорхой тийм зохицуулсан заалт байхгүй. Тэгэхдээ Татварын ерөнхий газар, Засгийн газраас тодорхой тодорхой чиглэл гаргаж тогтоол гаргасан гэсэн боловч тэн дээрээ яг тийм элементээс, элементийг ингэж ингэж авна, тооцож авна гэсэн ямар ч мэдээлэл байхгүй байгаа. Буцаагаад хуулийн зохицуулалтуудаа л нэрлэчихсэн байх жишээтэй. Тэгэхээр энэ дээр тодорхой хариултууд өгөөдхөөч. Тэгээд дараа нь тодруулъя.

**Д.Батбаяр:** Аудитын байгууллага 6 номерын микрофоныг нээе.

**Я.Самбууням:** Ерөнхий аудитын орлогч Самбууням байна. Батлут гишүүний асуултад хариулъя.

Бид Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.1-д заасан нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх гэдэг шаардлагын хүрээнд нь бол 2025 оны төсвийн төсөлд бол зэсийн үнийг тонн тутамд 7491.7 ам.доллар, нүүрсний үнийг тонн тутамд 129 ам.доллар байхаар тооцсоныг бол нягталсан. Мөн бол бид энэ Сангийн яамны боловсруулсан Эдийн засаг, хөгжлийн яамны гаргасан энэ харьцуулсан судалгаануудыг бас өөрсдийн хүрээнд бол Дэлхийн банкны гаргасан тооцооллууд дээр нь бол бас үндэслэж яг бүрэн хэмжээний бол тооцоолол хийгээгүй. Гэхдээ бол энэ зах зээлийн төлөв байдалтай нь бол харьцуулаад, тэгээд энэ дээрээсээ бол дүгнэлтээ гаргасан. Дүгнэлтдээ бол юу гэсэн бэ гэхээр зэрэг орлого бол тасалдах эрсдэлтэй байна. Тэгэхээр зэрэг дараагийн арга хэмжээг авахад бэлэн байгаач гэдэг ийм дүгнэлтийг бол гаргасан байж байгаа.

**Д.Батбаяр:** 9 номерын микрофон уул уурхайн бүтээгдэхүүн, зэс болон нүүрсний үнэ унах магадлалтай гэсэн бодол байгаа юм байна. Та нар ямар бодолтой байгаа вэ? Ямар судалгаа хийсэн бэ гэж асуусан.

**Л.Энх-Амгалан:** 2 бүтээгдэхүүн дээр. Зэс болон нүүрс дээр 2 төрлийн үнэ тооцож явдаг. Тэнцвэржүүлсэн үнэ болон зах зээлийн үнэ гэж. Тэнцвэржүүлсэн үнийг яг хуульд заасан заалтын дагуу хатуу тооцдог. Тэр 2 үнэ дээр ямар нэгэн байдлаар зах зээлийн үнэ ийм байна, хандлага ийм байна гээд энийг багасгая, ихэсгее гэдэг асуудал ярьдаггүй байгаа. Энэ тэнцвэржүүлсэн үнийг ашиглаад төсвийн сангуудад орох орлогыг тооцдог. Нийт төсвийн орлогыг яг зах зээлийн үнээр тооцдог.

Нүүрсний хувьд болон эхнээс өссөн, дундаж үнэ 1зуун найм, есөн доллар байна. Бидний хувьд ирэх оны үнийг 105 доллар гэж авсан байгаа. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс манайд судалгаа ирүүлсэн. Тэр дээр нүүрсний үнийг 107-132 долларын хооронд байна шүү гэдэг судалгаа ирүүлсэн.

**Д.Батбаяр:** хариулчихъя 9 номер.

**Л.Энх-Амгалан:** Зах зээл дээр нүүрсний үнэ унах эрсдэл байгаа. Тэрэнтэй уялдуулаад бид Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн доод хязгаар буюу 107 доллараос бага үнээр буюу 105 доллараар төсвийн орлого болон экспортыг тооцохдоо авч байгаа. Нэлээд бууруулж авч байгаа гэсэн үг.

Зэсийн хувьд 10 мянган доллараар авч байгаа. Зэс дээр цаашдаа эрэлт өндөр байгаа учраас зах зээлийн үнэ гайгүй тогтвортой байх болов уу гэсэн тийм хүлээлттэй байгаа гэдгийг хэлье.

**Д.Батбаяр:** 6 номерын микрофоныг нээе.

**Я.Самбууням:** Энэ яг энэ АМНАТ-ын бүх төрлийн ашигт малтмалд буюу бас энэ ховор элементэд ноогдуулж байгаа АМНАТ-ыг бол ер нь бол энийг бага хэмжээгээр тогтоодог юм байна лээ. Яг тодорхойлсон журамласан зохицуулалт байхгүй. Эрх зүйн зохицуулалт нь бол хангалтгүй юм байна лээ. Яагаад гэхээр зэрэг энийг бол өнгөрсөн жил бид ашигт малтмалын уул уурхайн бүтээгдэхүүн ноогдуулж байгаа АМНАТ-ын хуулийн хэрэгжилт гэсэн аудитаараа бол бас үзсэн. Тэгэхэд энэ дээр бол энэ дагалдах эрдэс баялагт ноогдуулж байгаа АМНАТ-ыг бол төвлөрүүлэх нь хангалтгүй байна гэсэн дүгнэлтийг гаргаж байсан. Ер нь бол хуулиараа бол энэ ноогдуулах нь зөв.

Яагаад гэхээр зэрэг одоо бид нарын бас энэ дараагийн эртээд бас Байнгын хороон дээр яригдаж байсан энэ Оюу толгойн аудит дээр бол бас энд дагалдах бүтээгдэхүүн дээр бол гарцаа байхгүй энийг тооцож, төсөвт орлогыг нь төвлөрүүлэх шаардлагатай.../минут дуусав./

**Д.Батбаяр:** Батлут гишүүн тодруулна. Микрофоныг нь.

**Д.Батлут:** Тэр Эдийн засаг, хөгжлийн яамныхан та нар тэр сайддаа сайн мэдээлэл өгөөрэй. Танай тэр сайд чинь ямар ч мэдээлэлгүй явж байгаа амьтан байна лээ шүү дээ чааваас. Жишээлбэл, 24 онд бид нар нүүрсээ 182 доллараар зарна гэж байсан бол 90 доллараар л дөнгөж зарж байсан түүх байгаа. Тэгээд олборлолтоо нэмэгдүүлж байсан. Та бүхэн санаж байгаа байх тийм ээ, экспортоо нэмэгдүүлж байсан. Тэгээд одоо юм мэдэхгүй байж байж тэр чуулган дээр хүнд уур бухимдлаа гаргаад загнаад байх ер нь шаардлага байхгүй шүү дээ. Та бүхэн тэгээд мэдээллийг нь сайн хангаж өгч байх хэрэгтэй шүү гэж хэлье.

Би энэ АМНАТ-тай, тэр дундаа энэ эдийн засгийн өгөөж бүхий дагалдах элементээс АМНАТ-тай холбоотой асуудал дээр нэлээн цаашаа судалж явна нөхөд өө. Энэ бол тухайн чиглэлийн боловсруулах үйлдвэрлэлүүд нь хийгдээгүй байгаа, хийхгүй байгаа зүйлийнхээ төлөө мөнгө төлж байгаа зүйл. Яг үнэндээ ингэснээрээ бид нар түүхийгээр нь түүхий эдээ экспортоллоо гэж хэлж байгаатай яг адилхан болж хувираад.../минут дуусав./

**Д.Батбаяр:** Та ахиад 1 минут авч болно. Батлут гишүүний микрофон.

**Д.Батлут:** Яг энэ асуудлаас чинь энэ давхар энэ АМНАТ буюу дагалдах элементээс АМНАТ аваад байгаагаас чинь болоод хувийн хэвшлийнхэн цөхөрч байгаа. 22 онд санагдаж байна 50-60 үйлдвэр, боловсрох л үйлдвэрт хаалгаа хаасан шүү дээ нөхөд өө. Энд бид нар өртөг шингэсэн үйлдвэрлэлийг дэмжих болохоос биш боомилоод байх шаардлагагүй гэж харж байгаа. Дэмжих л юм бол харин эдийн засагт том өгөөжийг өгнө. Боомилоод байх юм бол яах вэ хаалгаа



барина. Ингэснээрээ бид нар түүхийгээр нь тэр байгалийнхаа баялгийг экспортлох хэмжээнд оччих вий дээ нөхөд өө. Ер нь зүгээр Монголын төр тэгж үзэх гээд байгаа юм биш үү? Энэ зүйлээсээ бүгдээрээ салах хэрэгтэй байгаа юм аа. Тэгээд хуульд тодорхой биш байхад аудитын байгууллага нь ч гэсэн авах нь зөв гээд сууж байх юм. Тэр чин зэсийн, Эрдэнэт үйлдвэр бол зэс баяжуулдаг, зэсийн баяжмал гаргадаг, молибдены баяжмал гаргадаг л үйлдвэр. Тэр үйлдвэрлэлээ л хийдэг. Харин тухайн элементүүдийг ялгах ёстой мөнгө зарцуулдаг. Ялгаж чадахгүй төлбөр.../минут дуусав./

**Д.Батбаяр:** 9 номерын микрофон хариулна Эдийн засаг, хөгжлийн яам. Боловсруулах үйлдвэрийг ер нь дэмжих юм уу? Тэгж байгаа бол энэ давхар АМНАТ тооцох асуудал дээр ер нь ямар байр суурьтай байгаа юм бэ гэдэг дээр тодорхой хариулчхаарай.

**Л.Энх-Амгалан:** Би хариулж мэдэхгүй байна энэ дээр.

**Д.Батбаяр:** Сангийн сайдын микрофоныг нээе.

**Б.Жавхлан:** Тийм, Батлут гишүүний асуултад хариулъя.

Ер нь гишүүний зовлонг бол ойлгоод байна. Хэцүү хэцүү байгаа. Энэ яах вэ бүх юм 2 талтай гэдэг шиг л ийм л юм болчихоод байгаа юм. Оюу толгой дээр яг энэ маргаан явж байгаа. Одоо арбитр дээр яваад байгаа маргааны чинь яг нэг асуудал энэ байхгүй юу. Нөгөө дайвар бүтээгдэхүүнүүд дээр нь, эрдсүүд дээр нь бас АМНАТ тавиад байгаа юм. Тэгээд тэр дээр л яг л ийм зүйл.

Тэгэхээр Монгол Улсын татварын алба яадаг вэ гэхээр яг татварт заасан яг эдийн засгийн ангиллаар нь л татвараа тавина. Болохгүй гэсэн заалт байхгүй учраас бид нар авах ёстой гэдэг үүргээрээ явж байгаа байхгүй юу. Тэгэхээр, өөрөөр хэлбэл тэр баяжмал дотор байгаа дайвар, зэс молибденоос бусад дайвар бүтээгдэхүүн дээр жишээ нь эдийн засгийн үр ашигтай, үр ашиггүй гэдэг нэг цэг, таслал ч байхгүй. АМНАТ гэдэг маань өөрөө эдийн засгийн үр өгөөж, ашгаас хамааралгүйгээр авдаг төлбөр. Уурхай ашигтай ажиллаж байна уу, ашиггүй ажиллаж байна уу АМНАТ-аа энэ төлбөрөө төлж л байх ёстой. Дайвар дээр нь ч гэсэн ялгаагүй.

Одоохондоо ийм хуулийн зохицуулалттай байгаа учраас бид яах аргагүй лэнэ чинь.../минут дуусав./

**Д.Батбаяр:** Сайд Жавхлан гүйцээгээд хариулъя.

**Б.Жавхлан:** Энэ чинь өөрөө нөгөө яг Үндсэн хуулийн 6.2-оор ард түмний өмнөөс хурааж авч байгаа төлбөр учраас Монгол Улсын татварын алба авахаас өөр арга байхгүй.

Харин цаашдаа энэ бодлогын шийдэл дээр Ашигт малтмалын тухай хууль дээр ажлын хэсэг гарчихсан явж байгаа. Энэ дайвар бүтээгдэхүүнүүд дээрээ босгоод тавиад, ... дээр нь тавиад эндээс авах шаардлагагүй, тэр нь эдийн засгийн үр өгөөжгүй гэх нь бол миний харж байгаагаар буруу. Харин тэр нөгөө торгуулиа тавих ёстой. Торгуультай ийм дайвар бүтээгдэхүүнүүд дээр бол АМНАТ авах шаардлагагүй ч гэдэг юм уу ийм шийдлүүд гарч ирвэл манайхаас лав би бол шууд дэмжээд л явна. Хууль дээр тийм өөрчлөлт орвол тийм.

**Д.Батбаяр:** Би асуулт асууна. Аудитын байгууллагаас асуулт асууна. Сангийн яамнаас асуулт асууна.

2026 оны төсөвтэй нэгэнт хэлэлцэж байгаа учраас, аудитын байгууллага дүгнэлтээ танилцуулж байгаа учраас энэ дүгнэлттэй холбоотой асуулт асууна. Бид нар бараг 5 сарын турш төсөвтэй холбоотой асуулт асуудал ярилаа. Тэгээд Зарлагын хяналтын дэд хороон дээр энэ тайлантай холбоотой, нягтлан бодохын зөрчил гаргасан, аудитын тайлангийн дүгнэлт нь хязгаартай зөрчилтэй гаргасан энэ олон дүгнэлтүүд ирсэн.

Тэгэхээр аудитын байгууллагаас ийм асуулт байгаад байна. Ийм олон янзын ингээд маш олон их хэмжээний мөнгөний зөрчил гараад байдаг, улс хохироод байдаг. Тэгээд энэ дээр танай аудитын байгууллага энэ төрийн байгууллагуудыг төсөв захиран зарцуулагч нарыг сахилга баттай байх тал дээр хууль, дүрэм, журмаа хэрэгжүүлэх тал дээр нь ямар нэгэн байдлаар сургалт энэ тэр явуулж байгаа юу, сургалт явуулж байгаа юу, мэдээлэл өгч байгаа юу гэдэг асуулт байна.

Хоёрдугаарт нь Сангийн яамнаас асуулт байгаа юм. Яг энд ийм байна л даа. Одоо энэ орж ирж байгаа төсөв дээр энэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тоног төхөөрөмж гэхэд 5.5 тэрбум төгрөг гээд нэмэгдчихсэн байна. Нөгөө тал дээр нь энэ гаалийн шинэчлэл, Гаалийн ерөнхий газрын хороодын шуурхай удирдлагын төв хяналт шалгалтын тоног, төхөөрөмжийн бүтцийн дэд бүтцийн ажил 2019 онд эхэлсэн энэ ажил хасагдчихсан байх юм. 16 тэрбум 400 сая төгрөг. Тэгэхээр энэ яг ямар бодлогоор нэмж, хасаж байгаа вэ энэ төслүүдийг гэдэг ийм асуулт байна.

Аудитын байгууллага хариулах уу? 4 номерын микрофоныг нээе.

**Ц.Наранчимэг:** Байнгын хорооны даргын асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг.

Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн 8.9.1, 8.9.8-д заасны дагуу санхүүгийн тайлангийн аудитыг жил бүр хийж гүйцэтгэж байгаа. Хуулийн цаглаварт хугацаанд гаргаж тайланг хүргэж байгаа. Энэ санхүүгийн тайлангийн аудитаар бид 4 дүгнэлтийг өгдөг. Энэ аудитын олон улсын стандарт, аудитын дээд байгууллага олон улсын стандартын дагуу өгч байгаа өөрчлөлтгүй, хязгаарлалттай, сөрөг та татгалзсан гэсэн ийм 4 дүгнэлтийг өгч энэ тайланг хүргүүлж байгаа.

Бид нарын үүрэг бол энэ мэдээж дүгнэлтээ үнэн, зөв, бодитой гаргах ийм үүрэгтэй. Хуулийн хугацаанд дүгнэлтээ гаргаад бүх шатын төсөв захирагч нарыг 1, 2 дугаар гарын үсэг зурдаг албан хаагчдыг цуглуулж, тайлангаа нэг бүрчлэн танилцуулж өгдөг. Танай байгууллага дээр ийм зөрчил байна, ийм ийм алдаа байна. Энэ дээр 2 янзын асуудал байгаад байгаа. Алдаа гэдэг маань нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудлуудыг бид үнэн, зөв болгож залруулж тайланг зөв болгож баталгаажуулж тухайн байгууллагад өгч байгаа.

Зөрчил бол мэдээж хууль эрх зүй зөрчсөн ийм асуудлууд байгаад байгаа.

Сургалтуудыг төсвийн захирагч нар манай байгууллага яг энэ төсөв захирагч нарт сургалт явуулах ийм үүрэггүй. Гэхдээ бид төсөв захирагч нар өөрснөө санхүүгийн ажилтнуудаа болон холбогдох хүмүүсийг цуглуулаад аудитын байгууллагаас юун дээр анхаарах ёстой юм, юун дээр алдаад байгаа юм гэдэг асуудлаар бид сургалтуудыг хийж өгдөг хүсэлтийнх нь дагуу. Танай байгууллага, танай салбар ийм асуудал дээр алдаа, зөрчил гаргаад байна, энэ нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудлаар ийм сургалтууд авах шаардлага байгаад байна, ийм юман дээр алдаад байна. Зөрчил дээр ингээд хойшид ийм юм дээр анхаарах ёстой гэсэн сургалтуудыг төсвийн ерөнхийлөн захирагч, төвлөрүүлэн захирагч болон холбогдох удирдлагууд хүсэх юм бол бид очиж сургалтыг хийж өгдөг байгаа.

Дотооддоо аудит хийж байгаа аудиторуудаа бид өөрсдөө төрийн аудитын байгууллага сургалтын цахим системтэй. Цахим системээрээ бас бид дотооддоо сургаж байгаа. Мөн манайд гэрээгээр аудит хийж байгаа аудитын хуулийн этгээдүүдээ бас сургадаг.

Яагаад гэвэл аудит хийж байгаа хүмүүсийн маань өөрсдийн ур чадвар бас тодорхой хэмжээнд өндөр байж байж аудитыг хийх үүрэгтэй учраас.

**Д.Батбаяр:** Дэлгэржаргал дарга, Жавхлан сайдын микрофоныг нээе.

**Б.Жавхлан:** Батбаатар даргын асуултад хариулья.

Тэгэхээр гаалийн байгууллага маань 2019 оноос хойш гаалийн шинэчлэлийн хүрээнд гаалийн бүрдүүлэлт болон бусад харилцааг цахимжуулах 100 гаруй тэрбум төгрөгийн ийм хөтөлбөр явж байгаа. Жил болгон өсөж буураад л ингээд л явж байгаа.

Ирэх жилийн тавигдсан байсан төсвөөс тодорхой хэмжээний хасалт хийгдэх ийм шаардлагуудыг бид жишээ нь гааль бол манай харьяа байгууллага, татвар дээр бас ийм асуудлуудыг тавьж байгаа юм. Тэгэхээр энэ хасагдсан дүнгүүд өөр нэг эх үүсвэрт гаргах гэж тавигдсан дүн гэж ойлгож болохгүй. 2.4 их наяд төгрөгийн зардал хэмнэхэд бүх салбаруудаас танагдаж байгаа. Тэр өөрийн харьяа байгууллагуудаасаа бол бид нар дүн тавиад л хасна шүү дээ. Тэгэхэд бол, тэгэхээр тийм 16 тэрбум төгрөгийн ийм гаалийн шинэчлэлийн ажлын хүрээнд хийгдэж байгаа нийт төсвөөсөө хасахад хойтон эрсдэл учрахгүй нь. Тодорхой хэмжээнд үлдэж байгаа тулгамдсан ийм зүйлүүдээ тэндээсээ санхүүжилтээ хийгдээд явна.

Нөгөө талдаа юу нэмэгдэж байгаа вэ гэдгийг энэ.../минут дуусав./

**Д.Батбаяр:** Жавхлан сайд гүйцээгээд хариулчихъя. Жавхлан сайдын микрофоныг нээгээрэй.

**Б.Жавхлан:** Тэгэхээр нөгөө талд нэмэгдэж байгаа дүнгүүдийг бас энэнтэй шууд уяж ингэж хэлэх нь, хэлэх боломжгүй юм л даа. 2.4 их наяд хасагдаад, энэ талдаа нэмэгдэж байгаа, хасагдаж байгаа маш олон зүйлүүд байгаа. Тэр дунд жишээ нь Хөдөө аж ахуйн яамны тэр тоног төхөөрөмж, гэхдээ Хөдөө аж ахуйн яамны тоног төхөөрөмж чинь нийт дүнгээр 20 хувь хасагдаж байгаа биз дээ? Тийм, нийт дүнгээрээ хасагдаад л явж байгаа. Айн? Байнгын хороон дээр нь үү? Нийт тоног төхөөрөмжөөрөө 20 хувь хасагдаж байгаа биз дээ?

**Д.Батбаяр:** Би тодруулаад асуучихъя.

Жавхлан сайд энэ хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж бас энд нэмж орж ирж байгаа юм байна. Түрүүн бас Дамдинням гишүүн бас асууж байсан. Тэгэхээр Хөдөө аж ахуйн яам маань өөрөө Дархан-Уул аймаг руу нүүж байгаа. Энэ нүүлттэй холбоотойгоор Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын харьяанд байсан 3, 4 объект гэсэн үү? Тэгээд энэ 3, 4 объектыг хувьчилж магадгүй байгаа талаар ярьж байна лээ. Тэгэхээр энэ ер нь хэр зохистой юм бэ? Яам Дархан-Уул аймаг руу нүүхэд энд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын харьяанд байгаа объект өмчүүдийг борлуулаад тэгээд Дархан-Уул аймагт шинээр байр барина гэдэг нь хэр зохистой юм болоо? Энийг ер нь цааш цаашид энэ Төсвийн байнгын хороо руу ер нь оруулах ёстой юм байна. Та харин юу яая.

Асуулт асууж, гишүүд маань асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдтэй холбогдуулан зарчмын зөүүтэй санал гаргах гишүүн байна уу?

Би байгаа.

Хэдүүлээ байна ирц маань ямархуу байна? 1, 2, 3, 4, 5, 6. Түвшин гишүүн байна уу?

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай энийг эхлээд юугаа уншчихъя. Зарчмын зөрүүтэй саналаа эхлээд уншчихъя

Сургуулийн барилга, Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 34 дүгээр хороонд орших 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилга нийт төсөвт өртөг нь 15 тэрбум 795.2 сая төгрөг, энэ 2025 оны санхүүжих дүн нь 11 тэрбум 795.2 сая төгрөг гэсэн энэ заалтаас 1 тэрбум 800 сая төгрөг бууруулж, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр сургуулийн өргөтгөлийн барилга, 320 хүүхэдтэй өргөтгөлийн барилгын нийт төсөвт өртөг нь 7 тэрбум 113.1 сая төгрөг гэж байгаа. Энэ төслийн нэмэгдэх өртөг нь 1 тэрбум 800 сая төгрөг байна.

Энэ саналыг, энэ зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураая.

Айн, Үгүй би бас тайлбарлачихъя. Энэ яагаад гэхээр салбар дотроо байгаа төсөв байхгүй юу. Яг адилхан 2 сургууль байгаа адилхан. Хөдөөд ч гэсэн бас ажил явж, амьдарч байгаа байхгүй юу. Хүүхдүүд байгаад байгаа учраас адилхан дэмжээд явах ёстой. Нэгийг нь бүр нолилчихье гээгүй. Адилхан 1, 1-ийг нь эхлүүлээд явчихъя гэсэн ийм санал байгаад байгаа учраас Дэд хорооны гишүүд мөн та бүхэн дэмжиж өгнө үү гэж хүсье.

Саяын зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэдэг томъёоллоор санал хураалт.

Орсонгүй. Нэгэнт шууд.

Саяны санал 55.6 хувиар дэмжигдлээ.

Төхөөрөмжид бас би хуруугаа уншуулж амжаагүй. Тэгээд би бол дэмжсэнээр санал өгсөн байгаа. Протоколд тусгуулчихъя.

Өөр санал байхгүй байна.

Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Төсвийн зарлагын хяналтын дэд хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Батбаяр Төсвийн байнгын хорооны хуралдаанд уншиж танилцуулъя.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Гишүүддээ баярлалаа.

19.48 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

*Д.ОТГОНДЭЛГЭР*